



МОНГОЛ
УЛСЫН
ЗАСГИЙН
ГАЗАР

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2020 I-VI

Улаанбаатар хот
2020 оны 07 сарын 29 өдөр

ГАРЧИГ

ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ	1
1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ	2
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл.....	2
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	2
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого	3
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	5
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	5
2.1.1. Уул уурхай, олборлох салбар	5
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар	5
2.1.3. Газрын тосны салбар	5
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн	8
2.4. Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад.....	9
3. ГАДААД ХУДАЛДАА	10
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	10
3.1.1. Уул уурхай, олборлох салбар	15
3.1.2. Хүнд үйлдвэрийн салбар	16
3.1.3. Газрын тосны салбар	16
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт.....	16
3.2.1. Хүнд үйлдвэрийн салбар	17
3.2.2. Газрын тосны салбар	17



ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

Экспорт: 2020 оны эхний 6 сард уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 834 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 277 сая ам.доллараар буурлаа. Үүнээс чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 828 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 344 сая ам.доллараар тус тус буурав.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 6 дугаар сард 1,736 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 27%-иар, өмнөх сараас 1%-иар өслөө. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,755; 103 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 2%-иар, төмрийн хүдэр 5%-иар буурсан бол зэсийн үнэ болон төмрийн хүдэр өмнөх сараас 10%-иар тус тус өслөө. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 6 дугаар сард 75 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 17%-иар, өмнөх сараас 9%-иар буурлаа.

Импорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15%-иар буюу 434 сая ам.доллараар буурав. Импортын 15 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 4 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 229 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 130 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 82 сая ам.доллараар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 7 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 434 сая ам.доллараар буурлаа. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 53 хувиар буурсан хэдий ч өмнөх сараас 13 хувиар өсч тн тутамд 310 ам.долларт хүрэв.

Төсөвт төвлөрүүлсэн орлого: Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 832.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 624.8 тэрбум төгрөг буюу 42.9 хувиар буурсан байна.

Үнэ металлын тушаалт: 2020 оны эхний 7 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар үнэт металлын худалдан авалт 12.2 тн хүрэв.

Алт худалдан авалтын дундаж ханш: 1 гр алт худалдан авах дундаж ханш 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдөр 177,322.82 төгрөг байв.

Ханш: Америк долларын төгрөгтэй харьцах ханш 2020 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 2,844.42-т хүрэв.

Лондонгийн металлын бирж: 2020 оны эхний 7 дугаар сарын 28-ны өдөр 1 тн зэсийн үнэ 6,399.5 ам.доллар, 1 унц алт 1,948.7 ам.долларт хүрэв.



1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл (биет хэмжээгээр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020		Зөрүү	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзлэх хувь
			Төлөвлөгөө	I-VI сар		
1	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	42,000.0	8,676.2	33,323.8	20.7%
2	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	1,225.0	675.9	549.1	55.2%
3	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.тн	8,279.0	4,124.3	4,154.7	49.8%
4	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан) ¹	тн	19.0	7.9	11.1	41.5%
5	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх	мян.бар	6,649.0	951.1	5,697.9	14.3%
6	Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ²	мян.тн	111.0	66.6	44.4	60.0%
7	Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх ³	мян.тн	557.0	313.7	243.3	56.3%

Эх сурвалж: Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Монголбанк

1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 4,358.7 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1,190.1 тэрбум төгрөг буюу 21.4 хувиар буурсан байна.

Үүнээс, эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 832.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 624.8 тэрбум төгрөг буюу 42.9 хувиар буурсан байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхайн салбараас 779.0 тэрбум төгрөг буюу 17.9 хувь,
- Газрын тосны салбараас 33.8 тэрбум төгрөг буюу 0.8 хувь,
- Тусгай зөвшөөрлийн төлбөр 14.6 тэрбум төгрөг буюу 0.3 хувь,
- Бусад орлого 5.5 тэрбум төгрөг буюу 0.1 хувь.

Эрдэс баялгийн салбар⁴ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 19.1 хувийг бүрдүүлж байна.

¹ Монголбанканд тушаасан алт мэдээлэл болно. Тус дүнд мөнгөний мэдээлэл ороогүй болно.

² Цайр нь МУ-ын 2020 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

³ Хайлуур жонш нь МУ-ын 2020 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

⁴ Эрдэс баялгийн салбар гэдгийг Уул уурхай, газрын тосны салбараар энэхүү статистик мэдээлэлд оруулсан болно.



Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлт		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Гүйцэтгэлийн өөрчлөлт	
			2019	2020	2019 I-VI	2020 I-VI	Зөрүү	Хувь
Нийт дүн			3,404.1	3,529.6	1,457.7	832.9	-624.8	-42.9%
УУЛ УУРХАЙН САЛБАР								
Нийт дүн			3,000.0	3,194.5	1,314.2	779.0	-535.2	-40.7%
1	Алт		83.0	166.0	19.3	63.3	44.0	3.3 ¹
2	Зэс		1,304.0	1,160.0	578.8	377.2	-201.7	-34.8%
3	Нүүрс		1,311.0	1,493.5	613.5	247.7	-365.8	-59.6%
4	Бусад		302.0	375.0	102.6	90.9	-11.7	-11.4%
ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР								
5	Газрын тос		335.6	266.0	111.5	33.8	-77.7	-69.7%
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО								
Нийт дүн			68.5	69.1	32.0	20.1	-11.9	-37.2%
6	Тусгай зөвшөөрлийн төлбөр		42.9	36.0	16.3	14.6	-1.8	-10.7%
7	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр		2.3	5.0	3.0	3.7	0.7	22.2%
8	Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/		11.3	14.0	9.9	0.0	-9.8	-99.5%
7	Бусад орлого		12.0	14.1	2.8	1.8	-1.0	-35.8%

Эх сурвалж: Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 - дахин их

1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр улсын төсөвт 779.0 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Зэс 377.2 тэрбум төгрөг,
- Нүүрс 247.7 тэрбум төгрөг,
- Алт 63.3 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 33.4 тэрбум төгрөг,
- Төмөр 31.7 тэрбум төгрөг,
- Цайр 14.2 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 11.5 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 535.2 тэрбум төгрөг буюу 40.7 хувиар буурсан байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Алт 44.0 (3.3 дахин их) тэрбум төгрөг,
- Төмөр 19.2 (2.5 дахин их) тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 2.7 (8.8%) тэрбум төгрөг.



Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 365.8 (59.6%) тэрбум төгрөг,
- Зэс 201.7 (34.8%) тэрбум төгрөг,
- Цайр 29.3 (67.3%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 4.3 (27.2%) тэрбум төгрөг.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019		2020		Өөрчлөлт			
	VI	I-VI	VI	I-VI	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	154.0	1,314.2	125.3	779.0	-28.7	-18.7%	-535.2	-40.7%
Алт	3.5	19.3	18.3	63.3	14.8	5.2 ¹	44.0	3.3 ¹
Нүүрс	90.1	613.5	44.8	247.7	-45.3	-50.3%	-365.8	-59.6%
Цайр	2.2	43.5	0.9	14.2	-1.3	-59.5%	-29.3	-67.3%
Зэс	47.8	578.8	47.1	377.2	-0.7	-1.5%	-201.7	-34.8%
Төмөр	2.7	12.6	6.8	31.7	4.1	2.5 ¹	19.2	2.5 ¹
Хайлуур жонш	2.3	15.8	1.7	11.5	-0.6	-24.6%	-4.3	-27.2%
Бусад	5.4	30.7	5.7	33.4	0.3	4.9%	2.7	8.8%

Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар

Тайлбар: 1 - дахин их



2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.1. Уул уурхай, олборлох салбар

2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 12.8 сая тн нүүрс (9.7 сая тн чулуун нүүрс, 3.1 сая тн хүрэн нүүрс), 626.4 мян.тн зэсийн баяжмал, 7,884.3 кг алт, 2,981.2 тн молибдений баяжмал, 57.6 мян.тн хайлуур жоншны хүдэр, 41.4 мян.тн хайлуур жоншны баяжмал, 3,845.9 мян.тн төмрийн хүдэр, 2,232.6 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 34.9 мян.тн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад алт 2,347.7 кг буюу 42.4 хувь, молибдений баяжмал 409.2 тн буюу 15.9 хувь, төмрийн хүдэр 7.8 мян.тн буюу 0.2 хувь, төмрийн хүдрийн баяжмал 788.7 мян.тн буюу 54.6 хувь, хайлуур жоншны баяжмал 14.3 мян.тн буюу 52.6 хувиар тус тус өссөн байна.

Харин нүүрс 12.1 сая тн буюу 48.5 хувь (чулуун нүүрс 11.9 сая тн буюу 55.1 хувь, хүрэн нүүрс 176.6 мян.тн буюу 5.3 хувь), зэсийн баяжмал 55.3 мян.тн буюу 8.1 хувь, хайлуур жоншны хүдэр 8.4 мян.тн буюу 12.7 хувь, цайрын баяжмал 8.4 мян.тн буюу 19.5 хувиар тус тус буурсан байна.

2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 795.1 мян.тн баяжуулсан нүүрс, 235.3 мян.тн нүүрсэн шахмал түлш, 4.7 мян.тн катодын зэс, 11.2 мян.тн металл бэлдэц, 10.8 мян.тн металл цувимал, 3.4 мян.тн ган төмөр хийц, 40.2 тн цахилгааны утас тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсэн шахмал түлш 156.5 мян.тн буюу 198.5 хувиар өссөн байна.

Харин баяжуулсан нүүрс 548.1 мян.тн буюу 40.8 хувь, катодын зэс 1.6 мян.тн буюу 25.6 хувь, металл бэлдэц 4.8 мян.тн буюу 30.1 хувь, металл цувимал 5.7 мян.тн буюу 34.4 хувь, ган төмөр хийц 0.8 мян.тн буюу 19.2 хувь, цахилгааны утас 11.9 тн буюу 22.9 хувиар тус тус буурсан байна.

2.1.3. Газрын тосны салбар

2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 1,027.2 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад газрын тос 2.3 сая бар буюу 69.4 хувиар буурсан байна.



Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2019		2020		Өөрчлөлт			
			VI	I-VI	VI	I-VI	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1. Уул уурхай, олборлох аж үйлдвэр										
1.1	Нүүрс:	мян.тн	3,503.8	24,954.0	2,238.2	12,845.4	-1,265.5	-36.1%	-12,108.6	-48.5%
	- Чулуун нүүрс	мян.тн	3,151.7	21,639.8	1,867.0	9,707.8	-1,284.7	-40.8%	-11,932.0	-55.1%
	- Хүрэн нүүрс	мян.тн	352.1	3,314.2	371.2	3,137.6	19.2	5.5%	-176.6	-5.3%
1.2	Газрын тос	мян.бар	575.6	3,361.9	257.8	1,027.2	-317.8	-55.2%	-2,334.7	-69.4%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	88.4	681.6	107.8	626.4	19.4	22.0%	-55.3	-8.1%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	402.8	2,572.0	452.3	2,981.2	49.5	12.3%	409.2	15.9%
1.5	Алт	кг	1,721.2	5,536.6	2,247.3	7,884.3	526.1	30.6%	2,347.7	42.4%
1.6	Төмрийн хүдэр, баяжмал:	мян.тн	1,242.0	5,282.1	1,312.8	6,078.6	70.8	5.7%	796.5	15.1%
	- Төмрийн хүдэр	мян.тн	1,016.9	3,838.2	875.6	3,845.9	-141.2	-13.9%	7.8	0.2%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	225.1	1,443.9	437.1	2,232.6	212.0	94.2%	788.7	54.6%
1.7	Хайлуур жоншны хүдэр, баяжмал:	мян.тн	25.4	93.1	15.7	98.9	-9.7	-38.1%	5.9	6.3%
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	11.9	66.0	9.0	57.6	-3.0	-24.8%	-8.4	-12.7%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	13.5	27.1	6.8	41.4	-6.7	-49.9%	14.3	52.6%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	5.3	43.3	3.8	34.9	-1.5	-28.1%	-8.4	-19.5%
2. Боловсруулах аж үйлдвэр										
2.1. Хүнд аж үйлдвэр										
2.1.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	336.7	1,343.2	184.2	795.1	-152.5	-45.3%	-548.1	-40.8%
2.1.2	Нүүрсэн шахмал түлш	тн	18,600.0	78,822.9	2,167.0	235,274.0	-16,433.0	-88.3%	156,451.2	198.5%
2.1.3	Катодын зэс, 99%	тн	884.4	6,288.9	693.2	4,676.4	-191.1	-21.6%	-1,612.5	-25.6%
2.1.4	Металл бэлдэц	тн	2,540.7	16,059.2	3,249.4	11,226.3	708.7	27.9%	-4,832.9	-30.1%
2.1.5	Металл цувимал	тн	3,072.4	16,429.4		10,772.2	-3,072.4	-100.0%	-5,657.2	-34.4%
2.1.6	Ган төмөр хийц	мян.тн	0.9	4.2	0.7	3.4	-0.2	-20.7%	-0.8	-19.2%
2.1.7	Цахилгааны утас	тн	6.1	52.1	10.6	40.2	4.6	75.6%	-11.9	-22.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2019		2020		Өөрчлөлт			
	VI	I-VI	VI	I-VI	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,421.7	8,457.3	1,340.3	6,557.2	-81.3	-5.7%	-1,900.0	-22.5%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	991.8	6,070.1	961.6	4,435.7	-30.2	-3.0%	-1,634.4	-26.9%
Нүүрс олборлолт	414.6	2,676.5	228.8	1,215.0	-185.8	-44.8%	-1,461.5	-54.6%
Газрын тос олборлолт	82.3	502.5	24.5	120.5	-57.7	-70.2%	-382.1	-76.0%
Металлын хүдэр олборлолт	471.1	2,818.9	686.9	2,990.9	215.8	45.8%	172.0	6.1%
Бусад ашигт малтмал олборлолт	23.9	72.1	21.3	109.3	-2.5	-10.5%	37.2	51.5%
Боловсруулах аж үйлдвэр	350.1	1,780.6	300.4	1,501.0	-49.7	-14.2%	-279.6	-15.7%
Үүнээс, хүнд аж үйлдвэр	104.2	489.6	98.0	437.1	-6.1	-5.9%	-52.4	-10.7%
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	40.0	190.2	33.6	166.3	-6.5	-16.1%	-23.9	-12.6%
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10.7	76.7	11.4	65.6	0.7	6.8%	-11.1	-14.5%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	31.7	103.8	31.7	89.9	-0.0	-0.1%	-13.9	-13.4%
Төмрийн үйлдвэрлэл	20.1	115.2	20.9	113.5	0.8	4.0%	-1.7	-1.5%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1.6	3.7	0.5	1.9	-1.2	-72.4%	-1.8	-49.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 6.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (22.5%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (26.9%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 1.5 (54.6%) их наяд төгрөг, газрын тос олборлолт 382.1 (76.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Харин металлын хүдэр олборлолт 172.0 (6.1%) тэрбум төгрөг, бусад ашигт малтмал олборлолт 37.2 (51.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 6 дугаар сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 176.1 (15.1%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 144.4 (17.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 67.6 хувийг эзэлж байна.



2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2019		2020			Өөрчлөлт			
	VI	I-VI	VI	I-VI	Гад-дад	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,835.6	10,154.4	1,661.6	7,129.4	3,860.0	-174.0	-9.5%	-3,025.0	-29.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,314.7	7,081.0	1,165.9	4,431.8	3,197.2	-148.8	-11.3%	-2,649.2	-37.4%
Нүүрс олборлолт	470.4	2,708.0	204.7	1,003.6	729.8	-265.6	-56.5%	-1,704.4	-62.9%
Газрын тос олборлолт	78.6	474.6	23.4	99.7	88.3	-55.2	-70.3%	-374.8	-79.0%
Металлын хүдэр олборлолт	739.9	3,796.3	911.0	3,217.5	2,291.3	171.1	23.1%	-578.8	-15.2%
Бусад ашигт малтмалын олборлолт	25.9	102.1	26.8	110.9	87.8	0.9	3.5%	8.8	8.6%
Боловсруулах аж үйлдвэр	441.0	2,464.0	417.3	2,076.4	662.7	-23.7	-5.4%	-387.6	-15.7%
Үүнээс, хүнд аж үйлдвэр	157.3	1,049.9	174.2	792.3	562.4	17.0	10.8%	-257.6	-24.5%
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	83.7	658.3	81.8	385.5	356.7	-1.9	-2.2%	-272.7	-41.4%
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	13.4	82.4	12.9	62.2		-0.4	-3.3%	-20.2	-24.5%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	31.8	106.9	38.4	113.0		6.6	20.9%	6.1	5.7%
Төмрийн үйлдвэрлэл	26.8	198.7	40.7	229.8	204.9	13.9	52.0%	31.2	15.7%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1.6	3.7	0.4	1.7	0.8	-1.3	-77.1%	-2.0	-54.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 7.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 (29.8%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (37.4%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 1.7 (62.9%) их наяд төгрөг, газрын тос олборлолт 374.8 (79.0%) тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт 578.8 (15.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлөв. Харин бусад ашигт малтмалын олборлолт 8.8 (8.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 3.9 их наяд төгрөг буюу 54.1 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 3.2 их наяд төгрөг буюу буюу 82.8 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна. Гадаад зах зээлд борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний 71.7 хувийг металлын хүдэр олборлолт, 22.8 хувийг нүүрс олборлолт, 2.8 хувийг газрын тос олборлолт, 2.7 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбарын бүтээгдэхүүн тус тус эзэлж байна.



2.4. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

хүнээр

Салбар	2017	2018	2019	2020	Өөрчлөлт			
	I-VI сар				(5-3)=?, (5/3)=%	(5-4)=?, (5/4)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	66,294	71,469	76,166	82,628	11,159	15.6%	6,462	8.5%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	23,358	23,811	25,050	23,821	10	0.0%	-1,229	-4.9%
Нүүрс олборлолт	7,486	7,716	8,029	7,081	-635	-8.2%	-948	-11.8%
Газрын тос олборлолт	1,753	1,594	1,547	1,593	-1	-0.1%	46	3.0%
Металлын хүдэр олборлолт	12,304	12,756	13,727	13,191	435	3.4%	-536	-3.9%
Бусад ашигт малтмалын олборлолт	1,815	1,745	1,747	1,956	211	12.1%	209	12.0%
Боловсруулах аж үйлдвэр	28,507	30,759	34,141	31,732	973	3.2%	-2,409	-7.1%
Үүнээс, хүнд аж үйлдвэр	6,529	7,087	8,632	8,551	1,464	20.7%	-81	-0.9%
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	188	188	659	1,771	1,583	842.0%	1,112	168.7%
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1,239	1,332	2,095	1,712	380	28.5%	-383	-18.3%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	3,136	3,538	3,562	3,026	-512	-14.5%	-536	-15.0%
Төмрийн үйлдвэрлэл	1,757	1,705	1,948	1,830	125	7.3%	-118	-6.1%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	209	324	368	212	-112	-34.6%	-156	-42.4%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлбар: 1 - дахин их



3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 5.3 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.5 тэрбум ам.доллараар 22.6 хувиар буюу буурсан байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү 368.0 сая ам.доллараар эерэг гарсан байна.

сая ам.доллар

Үз-лт	Жилээр			Өөрчлөлт				I-VI сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	%	Дүн	%				Дүн	%	Дүн	%
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	6,341	6,833	5,288	492	8%	-1,544	-23%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	3,581	3,939	2,828	358	10%	-1,111	-28%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	2,759	2,894	2,460	135	5%	-434	-15%
Тэнцэл	1,865	1,137	1,493	-728	-39%	356	31%	822	1,045	368	223	27%	-677	-65%

3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2.8 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1.1 тэрбум ам.доллараар буюу 28.2 хувиар буурсан байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, тунгаасан эс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 94.0 хувийг эзэлж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2019	2020	Өөрчлөлт	
		I-VI сар		Өсөлт/бууралт	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	85.4	79.7	-5.7	-6.7%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,418.2	1,096.5	-321.7	-22.7%
Газрын тос	бар/ам.дол	56.6	35.7	-20.8	-36.9%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	61.2	68.7	7.5	12.2%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,480.9	1,201.9	-278.9	-18.8%
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	324.1	241.4	-82.6	-25.5%
Молибдений хүдэр, баяжмал	тн/ам.дол	8,811.0	6,813.5	-1,997.5	-22.7%
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	кг/ам.дол	41,997.8	55,259.2	13,261.5	31.6%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



Эрдэс бүтээгдэхүүний экспорт, тоо хэмжээгээр (2019)

Барааны нэр	Хэмжих нэгж	2019										
		1 сар	2 сар		3 сар		4 сар		5 сар		6 сар	
			Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр
Хайлуур жонш	мян.тн	53.6	15.6	69.2	41.4	110.6	41.2	151.8	69.7	221.5	64.9	286.4
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	608.6	572.8	1,181.4	890.3	2,071.8	770.4	2,842.1	647.1	3,489.2	625.8	4,115.1
Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн	117.4	112.0	229.4	132.0	361.4	127.7	489.1	135.2	624.3	124.8	749.2
Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн	1.6	1.4	3.0	2.3	5.3	1.3	6.6	2.8	9.5	2.4	11.9
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	12.0	12.6	24.6	19.3	44.0	10.1	54.1	10.8	64.8	7.5	72.4
Гянтболдын хүдэр, баяжмал	тн	20.0	25.0	45.0	5.0	50.0	40.0	90.0	73.0	163.0	41.3	204.3
Молибдений хүдэр, баяжмал	тн	480.0	455.9	935.9	459.9	1,395.8	468.3	1,864.1	456.9	2,321.0	488.6	2,809.6
Нүүрс	мян.тн	2,163.8	1,912.1	4,075.9	3,728.3	7,804.2	3,654.2	11,458.4	3,686.0	15,144.3	2,974.6	18,119.0
- Чулуун нүүрс	мян.тн	2,118.4	1,907.0	4,025.3	3,707.8	7,733.1	3,651.6	11,384.8	3,676.3	15,061.1	2,969.0	18,030.1
- Хүрэн нүүрс	мян.тн	45.4	5.2	50.6	20.4	71.1	2.5	73.6	9.7	83.3	5.6	88.9
Газрын тос	мян.бар	533.8	477.6	1,011.4	609.2	1,620.6	485.3	2,105.9	521.8	2,627.7	549.6	3,177.3
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн	3.1	1.6	4.7		4.7		4.7		4.7		4.7
Тунгаасан зэс ба хайлш	тн	760.0	761.0	1,521.0	760.8	2,281.8	760.5	3,042.3	760.7	3,803.1	761.0	4,564.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



Эрдэс бүтээгдэхүүний экспорт, тоо хэмжээгээр (2020)

Барааны нэр	Хэмжих нэгж	2020											Өөрчлөлт өссөн дүнгээр (2020/2019)	
		1 сар	2 сар		3 сар		4 сар		5 сар		6 сар			
			Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр
Хайлуур жонш	мян.тн	47.5	34.8	82.2	54.9	137.1	60.3	197.4	39.6	237.0	76.7	313.7	27.3	9.5%
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	815.5	612.0	1,427.4	634.4	2,061.8	674.7	2,736.5	712.5	3,449.0	675.3	4,124.3	9.2	0.2%
Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн	101.6	90.7	192.3	114.3	306.6	122.8	429.4	126.6	556.0	119.9	675.9	-73.3	-9.8%
Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн	2.9	2.3	5.2	2.4	7.6	3.0	10.6	2.4	13.0	0.7	13.7	1.8	15.1%
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	12.8	13.7	26.5	10.4	36.9	13.3	50.2	8.1	58.3	8.3	66.6	-5.8	-7.9%
Гянтболдын хүдэр, баяжмал	тн		4.0	4.0		4.0		4.0		4.0		4.0	-200.3	-98.0%
Молибдений хүдэр, баяжмал	тн	540.7	498.9	1,039.6	508.1	1,547.7	508.4	2,056.1	504.8	2,560.9	544.1	3,105.0	295.4	10.5%
Нүүрс	мян.тн	2,440.2	356.9	2,797.1	341.2	3,138.3	997.8	4,136.1	2,174.6	6,310.7	2,365.5	8,676.2	-9,442.8	-52.1%
- Чулуун нүүрс	мян.тн	2,425.5	354.9	2,780.4	341.2	3,121.6	997.8	4,119.4	2,171.5	6,290.9	2,362.3	8,653.2	-9,376.8	-52.0%
- Хүрэн нүүрс	мян.тн	14.7	1.9	16.7		16.7		16.7	3.1	19.7	3.2	23.0	-65.9	-74.2%
Газрын тос	мян.бар	287.7	0.0	287.7	34.6	322.3	165.7	488.1	175.8	663.8	287.3	951.1	-2,226.1	-70.1%
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн		1.6	1.6		1.6		1.6	3.4	4.9	6.1	11.0	6.3	135.2%
Тунгаасан зэс ба хайлш	тн	960.7	1,161.0	2,121.6	960.9	3,082.6	720.5	3,803.1	760.5	4,563.6	1,160.8	5,724.4	1,160.3	25.4%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тайлбар: 1 - дахин их



Эрдэс бүтээгдэхүүний экспорт, үнийн дүнгээр (2019)

Барааны нэр	Хэмжих нэгж	2019										
		1 сар	2 сар		3 сар		4 сар		5 сар		6 сар	
			Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр
Хайлуур жонш	сая USD	17.7	5.6	23.4	17.2	40.6	14.4	55.0	19.9	74.8	18.0	92.8
Төмрийн хүдэр, баяжмал	сая USD	26.0	26.1	52.2	54.3	106.5	52.5	159.0	48.4	207.5	44.3	251.8
Зэсийн хүдэр, баяжмал	сая USD	157.3	151.8	309.1	194.7	503.7	197.7	701.4	191.6	893.1	169.4	1,062.4
Хар тугалганы хүдэр, баяжмал	сая USD	3.7	3.3	7.0	5.3	12.3	2.9	15.2	6.1	21.3	4.5	25.9
Цайрын хүдэр, баяжмал	сая USD	17.1	17.3	34.4	28.2	62.6	16.1	78.7	17.2	95.8	11.3	107.1
Гянтболдын хүдэр, баяжмал	сая USD	0.2	0.3	0.5	0.1	0.6	0.4	0.9	0.7	1.7	0.5	2.2
Молибдений хүдэр, баяжмал	сая USD	4.2	4.0	8.2	3.7	11.9	4.2	16.2	4.2	20.3	4.4	24.8
Нүүрс	сая USD	170.8	163.4	334.2	310.0	644.2	319.3	963.5	310.8	1,274.3	269.1	1,543.5
- Чулуун нүүрс	сая USD	169.3	163.2	332.4	309.3	641.7	319.3	961.0	310.5	1,271.5	269.0	1,540.5
- Хүрэн нүүрс	сая USD	1.6	0.2	1.7	0.7	2.4	0.1	2.5	0.3	2.8	0.2	3.0
Газрын тос	сая USD	27.0	26.0	53.0	34.8	87.8	30.7	118.5	31.6	150.1	29.6	179.7
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	сая USD	130.1	65.9	195.9		195.9		195.9		195.9		195.9
Тунгаасан зэс ба хайлш	сая USD	4.4	4.5	8.9	4.8	13.7	4.8	18.4	4.6	23.0	4.3	27.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



Эрдэс бүтээгдэхүүний экспорт, үнийн дүнгээр (2020)

Барааны нэр	Хэмжих нэгж	2020											Өөрчлөлт өссөн дүнгээр (2020/2019)	
		1 сар	2 сар		3 сар		4 сар		5 сар		6 сар			
			Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Өссөн дүнгээр	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Тайлант сард	Өссөн дүнгээр	Өсөлт/бууралт	Хувь
Хайлуур жонш	сая USD	13.0	7.3	20.2	15.0	35.3	15.1	50.3	10.2	60.5	15.3	75.7	-17.1	-18.4%
Төмрийн хүдэр, баяжмал	сая USD	55.5	43.4	98.9	42.2	141.1	47.6	188.7	45.9	234.6	48.6	283.2	31.4	12.5%
Зэсийн хүдэр, баяжмал	сая USD	114.1	105.0	219.1	132.1	351.2	135.1	486.3	128.2	614.4	126.6	741.1	-321.4	-30.2%
Хар тугалганы хүдэр, баяжмал	сая USD	6.2	5.0	11.1	5.5	16.6	6.2	22.9	4.5	27.4	1.5	28.9	3.1	11.8%
Цайрын хүдэр, баяжмал	сая USD	18.0	17.5	35.5	12.8	48.3	14.2	62.6	8.4	70.9	9.1	80.1	-27.1	-25.3%
Гянтболдын хүдэр, баяжмал	сая USD	-	0.0	0.0	-	0.0	-	0.0		0.0		0.0	-2.1	-98.6%
Молибдений хүдэр, баяжмал	сая USD	3.8	3.5	7.3	3.9	11.2	3.5	14.7	3.0	17.7	3.5	21.2	-3.6	-14.5%
Нүүрс	сая USD	203.8	25.6	229.4	23.5	163.4	81.6	334.5	178.8	513.3	177.5	690.8	-852.7	-55.2%
- Чулуун нүүрс	сая USD	203.4	25.5	228.9	23.5	252.4	81.6	334.0	178.6	512.7	177.4	690.1	-850.4	-55.2%
- Хүрэн нүүрс	сая USD	0.4	0.1	0.5	-	0.5	-	0.5	0.1	0.6	0.1	0.7	-2.3	-76.6%
Газрын тос	сая USD	16.9	0.0	16.9	0.8	17.7	3.0	20.7	3.9	24.7	9.3	34.0	-145.7	-81.1%
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	сая USD	-	80.4	80.4	-	80.4	-	80.4	185.4	265.8	340.7	606.4	410.5	209.5%
Тунгаасан зэс ба хайлш	сая USD	5.7	6.4	12.1	5.2	17.3	3.5	20.8	3.8	24.5	6.2	30.8	3.4	12.6%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



3.1.1. Уул уурхай, олборлох салбар

Чулуун нүүрсний экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 690.1 сая ам.долларын 8.7 сая тн чулуун нүүрс экспортолсоныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр 850.4 сая ам.доллараар буюу 55.2 хувиар, биет хэмжээгээр 9.4 сая тн-оор буюу 52.0 хувиар тус тус буурсан байна. 1 тн чулуун нүүрсний экспортын дундаж үнэ 79.7 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.7 ам.доллараар буюу 6.7 хувиар буурсан байна. Чулуун нүүрсний 96.4 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 741.1 сая ам.долларын 675.9 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр 321.4 сая ам.доллараар буюу 30.2 хувиар, биет хэмжээгээр 73.3 мян.тн-оор буюу 9.8 хувиар тус тус буурсан байна. 1 тн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 1,096.5 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 321.7 ам.доллараар буюу 22.7 хувиар буурсан байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 283.2 сая ам.долларын 4.1 сая тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал үнийн дүнгээр 31.4 сая ам.доллараар буюу 12.5 хувиар, биет хэмжээгээр 9.2 мян.тн-оор буюу 0.2 хувиар тус тус өссөн байна. 1 тн төмрийн хүдэр, баяжмалын экспортын дундаж үнэ 68.7 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 7.5 ам.доллар буюу 12.2 хувиар өссөн байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 75.7 сая ам.долларын 313.7 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал биет хэмжээгээр 27.3 мян.тн буюу 9.5 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 17.1 сая ам.доллар буюу 18.4 хувиар буурсан нь экспортын дундаж үнэ 241.4 ам.доллар болж, 82.6 ам.доллар буюу 25.5 хувиар буурсантай холбоотой. Хайлуур жоншийг 75.3 хувийг БНХАУ руу, 24.3 хувийг ОХУ руу, БНСУ, Узбекистан руу экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 80.1 сая ам.долларын 66.6 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал биет хэмжээгээр 5.8 мян.тн буюу 7.9 хувиар, үнийн дүнгээр 27.1 сая ам.доллар буюу 25.3 хувиар тус тус буурсан байна. 1 тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,201.9 ам.доллар болж, 278.9 ам.доллар буюу 18.8 хувиар буурсан байна.

Молибдений баяжмалын экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 21.2 сая ам.долларын 3.1 мян.тн молибдений баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал үнийн дүнгээр 3.6 сая ам.доллар буюу 14.5 хувиар буурсан ч, биет хэмжээгээр 295.4 тн-оор буюу 10.5 хувиар өссөн байна. 1 тн молибдений баяжмалын экспортын дундаж үнэ 6,813.5 ам.доллар болж, 1,997.5 ам.доллараар буюу 22.7 хувиар буурсан байна. Молибдений баяжмалын 83.1 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 606.4 сая ам.долларын 11.0 тн алт экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнийн дүнгээр 410.5 сая ам.доллараар буюу 209.5 хувиар, биет хэмжээгээр 6.3 тн-оор буюу 135.2 хувиар тус тус өссөн байна. 1 кг алтны экспортын дундаж үнэ 55,259.2 ам.доллар болж, 13,261.5 ам.доллар буюу 31.6 хувиар өссөн байна.



3.1.2. Хүнд үйлдвэрийн салбар

Коксын экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 205.0 мян.ам.долларын 1.3 мян.тн кокс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнийн дүнгээр 11.9 сая ам.доллар буюу 98.3 хувиар, биет хэмжээгээр 55.8 мян.тн-оор буюу 97.8 хувиар тус тус буурсан байна.

Катодын зэс: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 30.8 сая ам.долларын 5.7 мян.тн катодын зэс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 1,160.3 тн-оор буюу 25.4 хувиар, үнийн дүнгээр 3.4 сая ам.доллар буюу 12.6 хувиар тус тус өссөн байна.

3.1.3. Газрын тосны салбар

Газрын тосны экспорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 34.0 сая ам.долларын 951.1 мян.бар газрын тос экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс биет хэмжээгээр 2,226.1 мян.бар-иар буюу 70.1 хувиар, үнийн дүнгээр 145.7 сая ам.доллар буюу 81.1 хувиар тус тус буурсан байна. 1 бар газрын тосны экспортын дундаж үнэ 35.7 ам.доллар болж, 20.8 ам.доллараар буюу 36.9 хувиар буурсан байна.

3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Эрдэс бүтээгдэхүүний импорт 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 2.5 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 433.7 сая ам.доллараар буюу 15.0 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт 485.4 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 136.5 сая ам.доллараар буюу 22.0 хувиар буурсан байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны нэр	Хэмжих нэгж	2019	2020	Өөрчлөлт	
		I-VI сар		Өсөлт/бууралт	Хувь
Автобензин	тн/ам.дол	590.3	433.8	-156.5	-26.5%
Дизель түлш	тн/ам.дол	626.8	446.9	-179.9	-28.7%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



3.2.1. Хүнд үйлдвэрийн салбар

Коксын импорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 96.8 мян.ам.долларын 528.9 тн кокс импортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 529.9 тн-оор буюу 50.0 хувиар, үнийн дүнгээр 87.3 мян.ам.доллараар буюу 47.4 хувиар тус тус буурсан байна.

3.2.2. Газрын тосны салбар

Эрдэс бүтээгдэхүүний импортын 81.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна. 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 393.5 сая ам.долларын 851.0 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 24.8 мян.тн-оор буюу 3.0 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 129.8 сая ам.доллар буюу 24.8 хувиар буурсан байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын 81.6 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 29.5 хувийг автобензин, 52.1 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 116.0 сая ам.долларын 267.3 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 15.2 мян.тн-оор буюу 6.0 хувиар өссөн ч, үнийн дүнгээр 32.9 сая ам.доллараар буюу 22.1 хувиар тус тус буурсан байна. 1 тн автобензины импортын дундаж үнэ 433.8 ам.доллар болж, 156.5 ам.доллараар буюу 26.5 хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт: 2020 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр 205.1 сая ам.долларын 458.9 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 110.3 сая ам.доллараар буюу 35.0 хувиар, биет хэмжээгээр 44.4 мян.тн буюу 8.8 хувиар тус тус буурсан байна. 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ 446.9 ам.долларт болж, 179.9 ам.доллараар буюу 28.7 хувиар буурчээ.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ